

## ТАНИЛЦУУЛГА

**2020.07.28**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 2005 онд батлагдан түүнийг дагалдан худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгүүд батлагдсан.

Төрийн худалдан авах ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах хүрээнд хуульд “7<sup>1</sup> дүгээр зүйл. Худалдан авах ажиллагаа дахь олон нийтийн оролцоо” зүйлийг 2011 онд нэмэлтээр оруулж, сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болох зохицуулалтыг бий болгосон. Хуулийн энэ нэмэлттэй холбоотойгоор “Журам, жишиг баримт бичиг батлах тухай” Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”, 2 дугаар хавсралтаар “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд санал авах жишиг баримт бичиг”-ийг тус тус баталж, өнөөдрийг хүртэл уг журам, жишиг баримтын дагуу захиалагч тендер шалгаруулалт зохион байгуулж байна.

Өнгөрсөн хугацаанд төсөв, санхүүгийн салбарт томоохон өөрчлөлтүүд орж, бодлогын баримт бичиг шинэчлэгдсэн төдийгүй барилга, эрчим хүч, авто зам зэрэг нийгэм эдийн засгийн харилцааг зохицуулж буй гол хуулиуд шинэчлэгдэн худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой зохион байгуулахад хүндрэл үүсэх болсон.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2019 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр багаа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан, мөн цахим худалдан авах ажиллагааны тогтолцоо руу шилжиж байгаатай холбоотой дээрх журам, тендерийн жишиг баримт бичгийг цахим тендер шалгаруулалтад нийцүүлэн өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн.

Шинэчлэн боловсруулсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”, “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерийн жишиг баримт бичиг”-ийн төсөлд сум, дүүргийн худалдан авах ажиллагааны нэгж, уг худалдан авах ажиллагаанд оролцогч иргэдийн бүлгээс авсан санал асуулга, ярилцлагад үндэслэн саналыг нэгтгэн дүн шинжилгээ хийж, тусгасан болно.

“Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”, “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерийн жишиг баримт бичиг”-ийн шинэчилсэн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгалаа. Үүнд:

- Журамд олон нийтийн оролцоотой зохион байгуулах төсөл, арга хэмжээг нэрлэж хязгаарласан байсныг хасаж, мөн хуульд заасан худалдан авах ажиллагааны аль ч журмаар зохион байгуулснаас үл хамааран захиалагч улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавих иргэдийг сонгон

шалгаруулах ажиллагааг олон нийтийн оролцоотой зохион байгуулж болох талаар зохицуулалтыг нэмж тусгасан;

- Журам, жишиг баримт бичгийг цаасан тендер шалгаруулалт болон цахим тендер шалгаруулалтын аль ч нөхцөлд хэрэглэх боломжтой байдлаар боловсруулсан;
- Захиалагч тендерт оролцогч болох иргэдийн бүлэгт тавих шалгуур болон бүрдүүлэх материалын талаар тендерийн баримт бичигт нэг шалгуур үзүүлэлтийг хэд хэдэн газар давхардуулж заах, нэмэлт материалыг хэд хэдэн хувилбараар шаардах, мөн хуулийн 14-16 дугаар зүйл нь хуулийн этгээдэд хамаарах шаардлага гэж ойлгогддог байдлыг цэгцлэн иргэдийн бүлгээс шаардаж болох материалыг тухайлан зааж, эдгээрээс тохирох шалгуурыг захиалагч сонгох боломжийг бүрдүүлсэн;
- Захиалагч заавал үнэлгээний хороо байгуулах шаардлагыг суманд зохион байгуулах төсөл, арга хэмжээний хувьд ажлын хэсэг байгуулж зохион байгуулах бололцоог бий болгосон;
- Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд тендер ирүүлэх иргэдийн бүлгийн тоог нээлттэй болгосноос гадна, оролцогчдод мэдээлэл хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс тендерийн урилгыг цахим системээр зарлахаас гадна тухайн төсөл, арга хэмжээ хэрэгжих баг, хорооны Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт байрлуулснаар уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зорилтод бүлэгт илүү ойртож, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг хангасан;
- Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам"-ын 5.2.6 дахь заалтын дагуу олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны үнийн санал авах баримт бичгийг 50,000.0-100,000.0 төгрөгөөр худалдан борлуулах зохицуулалт байгаа тул үүнийг журмын төсөлд сонирхсон иргэдийн бүлэг тендерийн баримт бичгийг цахим системээс үнэ төлбөргүй татан авах зохицуулалтыг тусгасан;
- "Иргэдийн бүлэг" нь хуулийн этгээдийн эрхгүй тул гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд иргэдийн бүлгийг төлөөлж бүлгийн ахлагчид хариуцлага хүлээлгэхийг тусгасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7<sup>1</sup> дүгээр зүйлийн 7<sup>1.3</sup> дахь хэсэгт заасны дагуу "Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам", "Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерийн жишиг баримт бичиг"-ийн төслийг тус тус шинэчлэн боловсруулж, санал авахаар хүргүүлж байна.